



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/503

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Налайх дүүргийн Ахмадын хорооноос хандивласан нийт 9,975,000.00 (есөн сая есөн зуун далан таван мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Байгал)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Байгал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцаа, даргын хам оны 12-дугаар сарын 1-ний өдрийн А/СХ-дугаар тушаал

Байгууллага: Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэр-лэсэн он	Чанар байдал	Хиймэл жигнэмэг	Бүртгэх анхны	Хандивлагч байгууллага			
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Хос дасгалын төхөөрөмж /нуруу, гэдэс, гар таталт/		хятад	2024	шинэ	ком	1	1,825,000.00	1,825,000.00	Налайх дүүргийн Ахмадын хороо	Хандив
2	Нурууны дасгалын төхөөрөмж 1		хятад	2024	шинэ	ком	2	1,675,000.00	3,350,000.00		
3	Хөлний дугуйн жийлтийн төхөөрөмж 1		хятад	2024	шинэ	ком	1	1,350,000.00	1,350,000.00		
4	Хөлний дугуйн жийлтийн төхөөрөмж 2		хятад	2024	шинэ	ком	1	1,200,000.00	1,200,000.00		
5	Нурууны дасгалын төхөөрөмж 2		хятад	2024	шинэ	ком	2	1,125,000.00	2,250,000.00		
Нийт дүн									9,975,000.00		